

“ДЭЭРЭЭС ТОГТООСОН ДҮРС ТУС БҮРИЙГ БҮРТГЭСЭН БИЧИГ” СУРВАЛЖИЙН ЗҮРХНИЙ ӨВЧНИЙГ ЗАСАХ ДАН ЭМИЙГ ТОДРУУЛАХ

Б.Бямбазая¹, Б.Гэрэлмаа², Ш.Болд³, Д.Шагдарсүрэн⁴

¹ЭЗШУИС, ²“Ач” АУИС, ³АШУУИС, ⁴“Долмалин” эмнэлэг

Б.Бямбазая E-mail: bbizi9088@gmail.com, 90889003

DETERMINATION OF MEDICINE FOR HEART TREATMENT ACCORDING TO “IMPERIALLY COMMISSIONED COMPLETE RECORD OF THE BODY” MANUSCRIPT

Byambazaya B.¹, Gerelmaa B.², Bold Sh.³, Shagdarsuren D.⁴

¹Mongolian University of Pharmaceutical Science, ²“Ach” Medical University, ³Mongolian

National University of Medicine Science, ⁴Dolmalin clinic

Б.Бямбазая E-mail: bbizi9088@gmail.com, 90889003

Abstract

Introduction: According to the manuscript “Imperially commissioned complete record of the body”, the study was selected to clarify the name of the plant, as it is difficult to recognize and translate the medicinal raw materials directly from Manchu, Tibetan, Chinese, Latin, and Sanskrit into Uighur and Mongolian scripts.

Methods: We conducted our research using hermeneutic, verification, and checklist methods.

Results

“Imperially commissioned complete record of the body” scripture is a rare book based on European anatomical works that combine Western and Eastern medical knowledge. There is reason to believe that European medicine in Mongolia was a witness to the spread of the anthropology of the human body.

It is clear from the 6 books that the two volumes are based on the basic tenets of Indian and Chinese medicine, Buddhist philosophy, and the teachings of the five elements and yin-yang.

The study included “Ingredients for Correcting Anxiety”, “Ingredients for Correcting Heart Attack,” and “Ingredients for Correcting Depression”. These three ingredients were the basis of the recipes of Oriental medicine in the European medical books. Comparing the taste, potency, and action of all selected medicinal raw materials using traditional medicine, such as “The quintessence Tantras of Tibetan Medicine” and other books, it is clear that the classical European medical tradition differs from the modern medical classification.

Conclusion

“Imperially commissioned complete record of the body” manuscript is a documentary scripture used by Mongolian shepherds and herdsmen on the achievements of European medicine, free from religious traditions and taboos. In addition, there found 18 traditional medicinal plants and 7 types of animal medicines used in heart disease.

Keywords: medical literature, the raw material of animal origin, herbal medicine, and prescription

Үндэслэл

Монгол анагаах ухааны биеийн бүтэц зүйн хөгжилд нөлөө үзүүлсэн манж хэлээр “Dergici toktobuha ge ti ciowan lu bithe”, монгол хэлээр “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”, олон улсад танигдсан нэр “Manchu Anatomy” хэмээх анагаах ухааны хосгүй ховор бүтээл билээ. Монгол эх нь манай улсын 108 үнэт өвийн нэгд зүй ёсоор багтдаг. Уг номыг Академич Б.Ринчен оршил бичиж гэрэл зургаар татан буулгаж, судалгааны эргэлтэд оруулахаар “Corpus scriptorum mongolorum” буюу “Монгол бичгийн чуулган” хэмээх цувралын XVII ботид 1971 онд 500 ширхэг хэвлэсэн нь өдгөө олдохгүй болжээ¹. Тус сурвалжид эмийн түүхий эдийг манж, төвөд, хятад, латин, санскрит зэрэг хэлнээс шууд галиглан уйгуржин монгол бичгээр буулгасан нь танин мэдэж практик хэрэглээнд нэвтрүүлэхэд хүндрэлтэй байдаг тул ургамлын нэршлийг тодруулахаар уг судалгааны ажлыг сонгон авлаа.

Зорилго

“Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” сурвалжийн доод ботийн эмчилгээний бүлэг дэх зүрхний өвчнийг засах дан эмийг тодруулан найрлага дахь ургамал болон амьтны гаралтай түүхий эдийг тогтоох.

Арга, аргачлал

Судалгааны үндсэн материал

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” сурвалжийн доод ботийн хоёр дэвтрийг судлахдаа Улсын төв номын санд буй ганц эхээс зураг татан буулгаж 1971 онд 500 хувь хэвлэсэн эх бичгийг ашигласан.

“Dergici toktobuha ge ti ciowan lu bithe” (хятадаар 格體全錄 Gé tǐ quán lù)- манж хэлээр бичсэн гар бичмэл хуулбар ном (нэмэлт 8 дугаар дэвтэр). Хувийн номын санд

хадгалагдаж байгаа эх.

Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг (ЗТХТЧЛБ). Балдан-Очир, хян. Өвөр монголын ШУТМХ, 1986.

Судалгааны арга

Герменевтик арга нь тайлбарлах тодруулах гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд сэдвийн өгүүлэмж, зохиогч, нэр томьёо, үгийн утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулахад герменевтик арга зүйг боловсруулсан. Түүнчлэн судалж буй зүйлийнхээ учир зүйг учир шалтгааны холбоогоор тайлбарлан судалдаг. Иймээс энэхүү аргыг судалж буй асуудлын нэр томьёог үгийн гарал, үүсэл далд утга, давхар санааг, агуулгыг судлан тогтоох зэрэгт ашиглав. Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар сурвалж бичгийн доторх ургамал болон амьтны гаралтай эмийн түүхий эдийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэхэд ашиглалаа.

Үр дүн

Монголд байсан “Dergici toktobuha ge ti ciowan lu bithe” буюу “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” хэмээх хоёр боть, 6 дэвтэр бүтээлийг чухам хэдий үед орчуулсныг одоогоор тогтоож амжаагүй байна. Магадгүй Фонтанейн хэлснээр: “Тэд өөрсдийн заах сургалтын материалаа татаар хэлээр бичдэг байсан. Дараа нь уг материалаа эзэн хаанд тайлбарлаж өгдөг бөгөөд хаан тэдний зааж байсан хичээлийг сайн ойлгож, бидний шинжлэх ухааныг улам биширч байлаа” хэмээсэнд үндэслэн Энх-Амгалан хааны үед монгол гар бичмэлээр байсан гэж таамаглах боломжтой юм. Судалгааны явцаас харахад “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” сурвалж Европын анатомийн бүтээлүүдэд суурилсан Өрнө-Дорнын анагаах ухааны мэдлэгийг харгалдуулан бичсэн ховор

ном бөгөөд Монголд Европын анагаах ухаан хүний биеийн бүтэц зүйн бүтээлээр дамжин дэлгэрч байсны гэрч хэмээн үзэх үндэстэй болно.

Энэхүү хоёр боть 6 дэвтэр бүтээлийг туурвихдаа Энэтхэг, Хятадын анагаах ухаан буддын гүн ухааны үндсэн иш онол таван махбод, “ин-ян” хийгээд “арга билиг”-ийн сургаалыг баримтлан туурвисан болох нь хоёр ботийн аль алинд тодорхой байна. Өөрөөр хэлбэл Энх-Амгалан хаан орчуулга бүрийг хянаж манж хэл зүй талаас нь сайжруулж байсны зэрэгцээ хятадын хар зурхайн 5 махбодын онолын зарим элементийг оруулж өгөхийг зөвлөмж болгож байжээ. Тиймээс Парренин эзэн хааны таалал ёсоор номын бүтэц, зохион байгуулалт ялангуяа цул, сав эрхтнүүдийг хар зурхайн 5 махбодын онолд нийцүүлэн төрөлжүүлсэн байна.

“Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийн доод ботийн 2 дэвтэрт буй өвчний үеийн үйл ажиллагааны өөрчлөлтийн зүй тогтлыг зохиогч нар өөр өөрсдийн ойлгосноор дорно дахины танин мэдэхүйн сургаалыг ашиглан тайлбарласан байх юм. Жишээлбэл: цусан хийн өвчин, халуун хүйтэн өвчин, хийн хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдөх гэх мэт.

Манжийн эзэн хаан Энх-Амгалан хаан 1692 онд 40 настай байхдаа хумхаа буюу чичрэг өвчнөөр өвдөж улмаар Европоос ирсэн шашны элч нарын бэлтгэж өгсөн *Cinchona cordifolia* модны холтсыг буцалган ууж эдгэсэн байна. Хумхаа бол шимэгчээр үүсдэг өвчин. Үүсгэгч бэлгийн ба бэлгийн бус үржлийн шатандаа байгаа *Plasmodium falciparum*, *P. vivax*, *P. ovale*, *P. malariae* зэрэг дөрвөн зүйлийн эгэл биет шимэгч болно. Хумхаа өвчин нутагшмал тархсан орнуудад эдгээр шимэгч хавсран үүсгэсэн халдвар элбэг тохиолддог.

Хүний хумхааг үүсгэдэг аль ч шимэгчээр нь үүсгэгдсэн өвчний шинж тэмдэг адилхан боловч лабораторийн шинжилгээ хийхгүйгээр үүсгэгчийг нь ялган оношлох боломж байхгүй. Хумхаагийн халдварууд дотроос хамгийн аюултай нь *P. falciparum*-аар үүсгэгдсэн хумхаа (ICD-9 084.0, ICD-10 B50) бөгөөд эмнэлзүйн хувьд олон янзын шинж тэмдгээр илэрдэг. Нобелийн шагналын хорооны мэдээнд жилд 200 сая хүн хумхаагийн халдвар авч², энэ өвчний улмаас дэлхий дахинд жил бүр 1 сая хүн нас барж байгаагийн дийлэнх нь Африкийн орнуудын хүүхдүүд байгаа юм. Африкийн халуун бүсийн бүх орон, Номхон далайн баруун өмнөд хэсэг, Өмнөд Америкийн Бразил зэрэг ой мод ихтэй орнууд, Зүүн Өмнөд Ази, Энэтхэгийн хойгийн зарим улс оронд энэ өвчин ихээхэн тархжээ³. Ийм хүнд өвчин туссан хаан эдгэсэн нь түүний Европын анагаах ухаанд шургуу суралцах хүсэл төрж тухайн үедээ Европт стандарт болж байсан анатомийн номыг заах, франц хэлнээс манж хэл рүү оруулах үүргийг шашин дэлгэрүүлэгч нарт даалгасан. Ингэхдээ зөвхөн манж хэлээр бүх бичлэгийг хийж байхыг тушаажээ. Ингэж “Dergici toktobuha ge ti ciowan lu bithe” ном бүтээгдэх эхлэлийг тавьсан байна.

Судалгаанд “Зүрх түгшихийг засах найрлага”, “Зүрх чичрэхийг засах найрлага”, “Муужрахыг засах найрлага”-уудыг хамруулсан. Энэ гурван найрлага нь Европ анагаах ухааны номонд буй дорно дахины анагаах ухааны суурьтай жорууд байлаа.

Table 1. List of herbal ingredients included in prescriptions for heart disease

№	Chinese name	Pinyin	Mongolian name
1	香橼露	Xiang Yuan Lu	Лемон нимбэгийн шүүс <i>Citrus medica L</i>
2	橙子露	Cheng Zi Lu	Жүржийн шүүс <i>Citrus sinensis</i>
3	玫瑰	Mei Gui	Нохойн хошууны хатаасан жимс <i>Rosa ssp</i>
4	独活的子	Du Huo De Zi	Shan et Yuan үндсийн гадаад хальс <i>Angelica pubescens Maxim. f. biserrate</i>
5	丁香	Ding Xiang	Лиш
6	桂皮	Gui Pi	Шинца
7	豆蔻的花	Dou Kou De Hua	Сүгмэлийн цэцэг
8	德里亚噶	De Li Ya Ga	Даряаган
9	番红花	Fan Hong Hua	Хач гүргэм <i>Crocus sativus L</i>
10	沉香	Chen Xiang	Хар агар
11	毕拨	Bi Bo	Библин
12	肉豆蔻	Rou Dou Kou	Задь
13	砂仁	Sha Ren	Улаан сүгмэл <i>Atomum villosum Lour</i>
14	良姜	Liang Jiang	Улаан гаа <i>Alpinia officinarum</i>
15	白檀香	Bai Tan Xiang	Цагаан зандан
16	黄蒿	Hang hao	Арүг буюу Ямаан шарилж <i>Artemisia scoparia waldst.et Kit</i>
17	冰片露	Bing Pian Lu	Гаврын жигнэсэн шүүс
18	玫瑰花露	Mei Gui Hua Lu	Сарнай цэцгийн шүүс

Table 2. List of animal ingredients included in prescriptions for heart disease

№	Chinese name	Pinyin	Mongolian name
1.	山羊宝	Shan Yang Bao	Хурганы засаа
2.	龙涎香	Long Xian Xiang	Халимын хув
3.	麝香	She Xiang	Заар
4.	鹿心	Lu Xin	Бугын зүрх
5.	鹿牙露	Lu Ya Lu	Бугын шүдний жигнэсэн шүүс
6.	牛心	Niu Xin	Үхрийн зүрх
7.	鹿房	Lu Fang	Бугын хөх

Зүрхний өвчнийг эмчлэх найрлагад орсон 1 дүгээр хүснэгт дэх 18 нэр төрлийн ургамлын гаралтай, 2 дугаар хүснэгтэд үзүүлсэн 7 төрлийн амьтны гаралтай, нийт 25 эмийн түүхий эдийн уламжлалт анагаах ухааны амт, чадал, үйлдлийг “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэс”⁴, Тойн Жамбалдоржийн “Бусдад үйлдэх судраас эмийн орон эндүүрэлгүй танин барих, үзэх арга, эмийн магад ургах үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршибай”⁵, “Эм таних ухаан”⁶ ӨМӨЗО-ны Лувсан багш тэргүүтэн судлаач нар 1998 онд орчуулж, тайлбар хийсэн, Монгол эмийн тухай товч гарын авлага (Дэүмар Данзанпунцагийн Хэр үгүй болор эрх судрын орчуулга)⁷ номыг ашиглан харьцуулж үзэхэд Европын анагаах ухааны сонгодог уламжлал илт байхын зэрэгцээ, орчин цагийн анагаах ухааны ангиллаас ялгаатай байгаа нь ажиглагдлаа.

Дүгнэлт

“Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” сурвалж бол шашны уламжлал, хорио цээрээс ангид европын анагаах ухааны ололтыг манай улсын оточ, маарамбууд ашиглаж байсан баримтат сурвалж бичиг болохын зэрэгцээ зүрхний өвчний үед хэрэглэгдэх уламжлалт анагаах ухааны 18 ургамал, 7 төрлийн амьтны гаралтай эмийн түүхий эд байгааг олж тогтоолоо.

Ном зүй

1. Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” (Эрхэлсэн проф. др. Ринчен). “Corpus Scriptorum Mongolorum”. Улаанбаатар, 1971, х.2.
2. Гэрэлмаа Б. “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” сурвалжийн эх бичгийн судалгаа. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар, 2020.
3. Dagdanbazar B. On defining the role of the research works of Mongolian doctors and zodch in the development of modern anatomy. Dissertation for Doctor of the Medical Science: Ulaanbaatar, Mongolia, 2002.
4. Bold Sharav. History and Development of Traditional Mongolian Medicine. Ulaanbaatar, Mongolia, 2013.
5. Press Release, 2021-10-05. The Nobel Assembly at Karolinska Institutet. <http://www.nobelprize.org>. Эшлэл авсан 2021.10.10
6. Халдварт өвчний хяналтын лавлах. 18 дахь хэвлэл. П.Нямдаваа, ред. Улаанбаатар, 2010, х.638-642.
7. “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэс”ийн “Номлолын үндэс”. Модон барын монгол судар.
8. Тойн Жамбалдорж. གཞན་ཡང་བྱ་བར་མདྲོ་ལས་གནས་སྒྲན་ངོས་འཛིན་འབྲུལ་སྤོ་ཆེས་སྤང་བཞེགས་ཐབས་སྒྲན་གྱི་འབྲུངས་དེས་མཛོས་ཆད་མིག་རྒྱན་ཅེས་བྱ་བ་བཞུགས། Бусдад үйлдэх судраас эмийн орон эндүүрэлгүй танин барих, үзэх арга, эмийн магад

- ургах үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх
оршибай. Модон барын төвөд судар
9. Эм таних ухаан. Лувсан, бусад, орч.
ӨМӨЗО, 1998, 4 хэсэг.
10. Монгол эмийн тухай товч гарын авлага
(Дэүмар Данзанпунцагийн Хэр үгүй
болор эрх судрын орчуулга). ӨМ-ын
Ардын хэвлэлийн хороо, 1964, х.16.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:

АШУ-ы доктор, проф, Академич

Д.Дагвацэрэн